



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/107

Бүрэн сум

Архи, согтууруулах ундаа худалдан
борлуулахыг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалт, 29.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд II ээлжийн цэрэг татлагын ажил зохион байгуулагдахтай холбогдуулан нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Дээрх хугацаанд хүнсний дэлгүүрүүдийн архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй, түүгээр үйлчлэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Хүнс, Жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Оюунсүрэн), Хэсгийн Төлөөлөгч (Б.Отгонбаяр), Хэсгийн цагдаа (Т.Цогтоо) нарт даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Г.Түвшинжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Б.ОТГОНХИШИГТ

410500286